



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Бугат сумын Зүүнгарын говийн дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/77/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413      Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055      Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор                      Х.Билэгбаяр Утас: 94009818      Цахим хаяг: Bilegbayarkh@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
3. Аудитын тайлан .....	4
3.1 Ерөнхий зүйл .....	4
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	4
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	4
3.4 Материаллаг байдал .....	5
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	5
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	6
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	7
3.8 Аудитын гол асуудал .....	7
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	8
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	8
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	8
4. Аудитын илрүүлэлт .....	9
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	11

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13, Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25

№

69

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Бугат сумын Зүүнгарын говийн дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Говь-Алтай аймгийн Бугат сумын Зүүнгарын говийн дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Амралт цалин давхардуулан цалин олгосон, сэлбэг хэрэгсэл эдэлгээний доод хязгаар баримтлаагүй, авто машины хувийн хэрэг хөтлөөгүй, жолоочийн замын хуудасгүй шатахуун зарцуулсан, эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн, авто машины тооцоолол хийх норм баримтлаагүй, батлагдсан төсвийг 10 хувиас доошгүй хэмнэлт гаргахаар ажиллаагүй, татварын тодорхойлолтыг илүү, дутуу тооцоолсон зэрэг 35.7 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал, Зам, тээвэр хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаал, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН БУГАТ  
СУМЫН ЗҮҮНГАРЫН ГОВИЙН  
ДАРХАН ЦААЗАТ ГАЗРЫН  
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ  
ДАРГА О.ГАНБААТАР ТАНАА

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>90,479,613.80</b>	<b>160,453,944.55</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	59,860,216.80	114,518,227.06
33300	Татаас, санхүүжилтийн авлага	59,860,216.80	114,271,388.36
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/		246,838.70
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	30,619,397.00	45,935,717.49
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	30,619,397.00	45,935,717.49
35410	Бичиг хэргийн материал	60,640.00	171,965.00
35420	Аж ахуйн материал	18,063,539.50	36,634,534.99
35470	Бусад хангамжийн материал	12,495,217.50	9,129,217.50
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>176,936,922.57</b>	<b>299,471,916.67</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	176,936,922.57	299,471,916.67
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	176,936,922.57	299,471,916.67
39201	Барилга, байгууламж, орон сууц	14,664,000.00	59,113,900.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(4,545,947.03)	(8,875,050.89)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	210,471,460.00	300,385,460.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(102,037,909.84)	(106,412,053.28)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	36,492,703.25	45,792,703.25
39206	Хуримтлагдсан элэгдэл	(14,926,920.41)	(23,056,393.97)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,898,518.43	7,898,518.43
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,508,203.89)	(4,171,055.57)
39214	Бусад үндсэн хөрөнгө	54,500,000.00	54,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(22,102,777.94)	(25,736,111.30)
39217	Ном	32,000.00	32,000.00
39301	Программ хангамж	495,000.00	495,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(495,000.00)	(495,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>267,416,536.37</b>	<b>459,925,861.22</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>267,416,536.37</b>	<b>459,925,861.22</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	267,416,536.37	459,925,861.22
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	<b>50,982,667.98</b>	<b>50,982,667.98</b>
51101	Өмч: - төрийн	50,982,667.98	50,982,667.98
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	214,926,084.22	407,435,409.07
51210	Өмнөх үеийн үр дүн	214,926,084.22	214,926,084.22
51220	Тайлант үеийн үр дүн	-	192,509,324.85
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,507,784.17	1,507,784.17
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>267,416,536.37</b>	<b>459,925,861.22</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1.00</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>627,327,576.80</b>	<b>780,428,282.91</b>
<b>12.00</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>122,410,060.00</b>	<b>116,609,000.00</b>
<b>120.00</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	122,410,060.00	116,609,000.00
120,004.00	Төсөв байгууллагын өөрийн орлого	122,410,060.00	116,609,000.00
1,200,045.00	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	122,410,060.00	116,609,000.00
<b>13.00</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>504,917,516.80</b>	<b>663,819,282.91</b>
<b>1,310.00</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	403,484,000.00	386,834,900.00
131,001.00	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	403,484,000.00	386,834,900.00
<b>1,311.00</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	101,433,516.80	276,984,382.91
131,101.00	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	101,433,516.80	276,984,382.91
<b>2.00</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>472,834,678.61</b>	<b>587,918,958.06</b>
<b>21.00</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>472,834,678.61</b>	<b>587,918,958.06</b>
<b>210.00</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	412,462,585.08	466,666,038.68
<b>2,101.00</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	149,241,176.00	152,385,609.00
210,101.00	Үндсэн цалин	107,417,076.00	120,688,966.20
210,102.00	Нэмэгдэл	25,639,500.00	25,974,143.00
210,103.00	Унаа хоолны хөнгөлөлт	5,588,000.00	5,722,499.80
<b>2,102.00</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	21,065,865.47	19,596,749.28
210,201.00	Тэтгэврийн даатгал	14,760,865.47	13,551,383.90
210,202.00	Тэтгэмжийн даатгал	1,576,300.00	1,511,342.00
210,203.00	ҮОМШӨ-ний даатгал	1,261,000.00	1,209,073.36
210,204.00	Ажилгүйдлийн даатгал	315,300.00	302,268.64
210,205.00	Эрүүл мэндийн даатгал	3,152,400.00	3,022,681.38
<b>2,103.00</b>	<b>Байр ашиглалттай хөлбоотой тогтмол зардал</b>	2,321,000.00	2,686,700.00
210,301.00	Гэрэл, цахилгаан	940,200.00	815,400.00
210,302.00	Түлш, халаалт	1,253,000.00	1,759,800.00
210,303.00	Цэвэр, бохир ус	127,800.00	111,500.00
<b>2,104.00</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	58,497,410.00	41,727,742.00
210,401.00	Бичиг хэрэг	330,400.00	298,225.00
210,402.00	Тээвэр, шатахуун	56,728,550.00	39,898,148.00
210,403.00	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,303,460.00	1,381,369.00
210,406.00	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	135,000.00	150,000.00
<b>2,105.00</b>	<b>Нормативт зардал</b>	194,000.00	6,291,420.40
210,503.00	Нормын хувцас, зөөлөн эдлэл	194,000.00	6,291,420.40
<b>2,106.00</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	18,086,000.00	25,772,927.10
210,601.00	Багаж, техник, хэрэгсэл	86,000.00	1,111,111.10
210,604.00	Урсгал засвар	18,000,000.00	24,661,816.00

Говь-Алтай аймгийн Бугат сумын Зүүнгарын говийн дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2,107.00	Томилолт, зочны зардал	7,052,700.00	9,779,600.00
210,702.00	Дотоод албан томилолт	7,052,700.00	9,779,600.00
2,108.00	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	111,106,055.00	160,601,385.00
210,801.00	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	110,832,835.00	160,312,765.00
210,804.00	Тээврийн хэрэгслийн татвар	41,220.00	42,620.00
210,806.00	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	232,000.00	246,000.00
2,109.00	Бараа үйлчилгээний бусад зардал	44,898,378.61	47,823,905.90
210,903.00	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	43,810,818.61	47,823,905.90
213.00	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,372,093.53	121,252,919.38
2,133.00	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	60,372,093.53	121,252,919.38
213,303.00	Төвлөрүүлэх шилжүүлэг	60,372,093.53	121,252,919.38
3.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>154,492,898.19</u>	<u>192,509,324.85</u>
5.00	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>154,492,898.19</u>	<u>192,509,324.85</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	50,982,667.98	1,507,784.17	214,926,084.22	267,416,536.37
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	50,982,667.98	1,507,784.17	214,926,084.22	267,416,536.37
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	192,509,324.85	192,509,324.85
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	50,982,667.98	1,507,784.17	407,435,409.07	459,925,861.22

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>504,917,516.80</u>	<u>609,408,111.35</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>504,917,516.80</u>	<u>609,408,111.35</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	403,484,000.00	386,834,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	403,484,000.00	386,834,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	101,433,516.80	222,573,211.35
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	101,433,516.80	222,573,211.35
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>500,017,516.80</u>	<u>555,658,211.35</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>500,017,516.80</u>	<u>555,658,211.35</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>379,785,206.47</u>	<u>434,405,291.97</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	149,241,176.00	152,385,609.00
210101	Үндсэн цалин	107,417,076.00	120,688,966.20
210102	Нэмэгдэл	25,639,500.00	25,974,143.00

Говь-Алтай аймгийн Бугат сумын Зүүнгарын говийн дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210103	Унаа хоолны хөнгөлөлт	5786000.00	5,722,499.80
210105	Гэрээт ажлын хөлс	10,398,600.00	-
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	21,065,865.47	19,843,587.98
210201	Тэтгэврийн даатгал	14,760,865.47	13,798,222.60
210202	Тэтгэмжийн даатгал	1,576,300.00	1,511,342.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,261,000.00	1,209,073.36
210204	Ажилгүйдлийн даатгал	315,300.00	302,268.64
210205	Эрүүл мэндийн даатгал	3,152,400.00	3,022,681.38
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	3,023,000.00	2,686,700.00
210301	Гэрэл, цахилгаан	940,200.00	815,400.00
210302	Түлш, халаалт	1,955,000.00	1,759,800.00
210303	Цэвэр, бохир ус	127,800.00	111,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	58,583,110.00	41,734,067.00
210401	Бичиг хэрэг	359,300.00	304,550.00
210402	Тээвэр, шатахуун	56,728,550.00	39,898,148.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,345,260.00	1,381,369.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	150,000.00	150,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	194,000.00	6,291,420.40
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	194,000.00	6,291,420.40
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	21,175,300.00	28,878,802.59
210601	Багаж, техник, хэрэгсэл	3175300.00	1,111,111.10
210602	Тавилга	0.00	27,767,691.49
210604	Урсгал засвар	18,000,000.00	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	7,052,700.00	9,779,600.00
210702	Дотоод албан томилолт	7,052,700.00	9,779,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	119,339,555.00	172,700,505.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	119066335.00	172,411,885.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	41220.00	42,620.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	232,000.00	246,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	110,500.00	105,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	110,500.00	105,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>120,232,310.33</b>	<b>121,252,919.38</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	120232310.33	121,252,919.38
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	120232310.33	121,252,919.38
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>4,900,000.00</b>	<b>53,749,900.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>4900000.00</b>	<b>53,749,900.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>4900000.00</b>	<b>53,749,900.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>4900000.00</b>	<b>53,749,900.00</b>

Говь-Алтай аймгийн Бугат сумын Зүүнгарын говийн дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,900,000.00	53,749,900.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-4900000.00</b>	<b>(53,749,900.00)</b>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	388,184,900.00	379,853,368.98
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	388,184,900.00	379,853,368.98
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	388,184,900.00	379,853,368.98
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	157,616,000.00	152,385,609.00
210101	Үндсэн цалин	121,937,500.00	120,688,966.20
210102	Нэмэгдэл	29,846,900.00	25,974,143.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,831,600.00	5,722,499.80
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	21,278,100.00	19,843,587.98
210201	Тэтгэврийн даатгал	14,973,500.00	13,798,222.60
210202	Тэтгэмжийн даатгал	1,576,200.00	1,511,342.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,260,900.00	1,209,073.36
210204	Ажилгүйдлийн даатгал	315,200.00	302,268.64
210205	Эрүүл мэндийн даатгал	3,152,300.00	3,022,681.38
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	2,686,700.00	2,686,700.00
210301	Гэрэл, цахилгаан	815,400.00	815,400.00
210302	Түлш, халаалт	1,759,800.00	1,759,800.00
210303	Цэвэр, бохир ус	111,500.00	111,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	38,494,400.00	38,485,567.00
210401	Бичиг хэрэг	305,400.00	304,550.00
210402	Тээвэр, шатахуун	36,651,500.00	36,649,648.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,386,000.00	1,381,369.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	151,500.00	150,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	194,000.00	194,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	194,000.00	194,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,911,400.00	3,839,600.00
210702	Дотоод албан томилолт	3,911,400.00	3,839,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	163,737,300.00	162,313,305.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	163,091,300.00	162,024,685.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	99,000.00	42,620.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	246,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	105,400.00	105,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	105,400.00	105,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	388,184,900.00	379,853,368.98
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	386,834,900.00	379,853,368.98
131001	Улсын төсвөөс санхүүжих	386,834,900.00	379,853,368.98

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>222,573,211.35</b>
21.00	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>222,573,211.35</b>
210.00	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	108,301,822.99
<b>2,104.00</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,248,500.00
210,402.00	Тээвэр, шатахуун	3,248,500.00
<b>2,105.00</b>	<b>Нормативт зардал</b>	6,097,420.40
210,503.00	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,097,420.40
<b>2,106.00</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	82,628,702.59
210,601.00	Багаж, техник, хэрэгсэл	10,411,111.10
210,602.00	Тавилга	44,449,900.00
210,604.00	Урсгал засвар	27,767,691.49
<b>2,107.00</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	5,940,000.00
210,702.00	Дотоод албан томилолт	5,940,000.00
<b>2,108.00</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	10,387,200.00
210,801.00	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,387,200.00
<b>213.00</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	114,271,388.36
<b>2,133.00</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>114,271,388.36</b>
213,303.00	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	114,271,388.36
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>222,573,211.35</b>
<b>1,311.00</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>222,573,211.35</b>
131,101.00	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	222,573,211.35

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Бугат сумын Зүүнгарын говийн дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал

татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Билэгбаяр гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Бугат сумын Зүүнгарын говийн дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн 08 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Говь-Алтай аймгийн Бугат сумын Зүүнгарын говийн дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа нь "Байгаль орчныг хамгаалах, тахь сэргээн нутагшуулах зорилготой" байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зерчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Бугат сумын Зүүнгарын говийн дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зарлага 384.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 7.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 6.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлын нийт зардал 587.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 11.8 сая төгрөг, 80 хувь буюу 9.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлогдож байна.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Говь-Алтай аймгийн Бугат сумын Зүүнгарын говийн дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 29 хувиар буюу 78.2 сая төгрөгөөр өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Авлага дансны үлдэгдэл оны эцэст 0.2 сая төгрөг болж 0.2 сая төгрөгөөр өссөн нь нийгмийн даатгалын шимтгэлийг илүү төлсөнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 45.9 сая төгрөг болж 15.3 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 126.9 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 111.6 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 468.2 сая төгрөг болж 143.7 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 53.7 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 116.6 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр хүлээн авсантай холбоотой байна. Тайлант оны эцэст 468.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 345.4 сая төгрөг болж 78.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 292.9 сая төгрөг болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 395.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслийг 388.1 төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс 7.5 сая төгрөгөөр буурсан нь тээвэр шатахуун, байгаль хамгаалах сангийн зардлыг тодотгосонтой холбоотой байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 4 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 388.1 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр 1.3 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө тасарч, улсын төсвөөс 386.8 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 379.8 сая төгрөгийг зарцуулж 7.0 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 379.8 сая төгрөг буюу 98 хувьтай байгаа нь 7.0 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 223.0 сая төгрөгийн орлого хүлээн авсан ба 108.7 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулж, 114.3 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Авто машины сэлбэг засвар үйлчилгээ, шатахууны зарцуулалтыг холбогдох хууль тогтоомжинд нийцүүлэн зарцуулан хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт худалдан авалтын И баримтыг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Говь-Алтай аймгийн Бугат сумын Зүүнгарын говийн дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа нь 2021 онд нийт 386.8 сая төгрөгийн 146 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим системд ил тод байршуулахаас 386.8 сая төгрөгийн 146 мэдээллийг ил тод бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт**

Тайлант онд 83.4 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг дутуу шивүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4.7 сая төгрөгийн төлбөрийн акт, зөрчил арилгах 1 заалттай албан шаардлага хүргүүлснийг биелүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараа жилийн аудитаар: Бараа материалын дансны үлдэгдлийг тулган баталгаажуулах, авлагын барагдуулалт, төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 233.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 114.7 сая төгрөгийг залруулан, 1.1 сая төгрөгийн төлбөрийн акт, 118.1 сая төгрөгийн албан шаардлага хүргүүллээ.

### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар санхүүгийн үр дүнгийн тайланг 114.7 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залрууллаа.

## 4.2 Төлбөрийн акт

- Жолоочийн замын хуудасгүй, анхан шатны баримтгүйгээр 0.9 сая төгрөгийн шатахуун зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-т "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хөдөлмөрийн үр дүнд тохируулан олгоно", Төрийн албаны тухай хуулийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.
- Амралтын цалинг давхардуулан 1 ажилтанд 0.2 сая төгрөгийн цалин илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-т "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хөдөлмөрийн үр дүнд тохируулан олгоно", Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

## 4.3 Албан шаардлага

- Эдийн засгийн ангилал зөрчиж цалингийн зардлаас 1.3 сая төгрөгийн гүйлгээ хийсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- Авто машины спидометрийн заалт, зарцуулалтын нормыг баримтлалгүйгээр 6.8 сая төгрөгийн шатахуун зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Зам, тээвэр хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- Сэлбэг, хэрэгслийн эдэлгээний доод хязгаарыг баримтлалгүйгээр 25,367.7 мянган төгрөгийн сэлбэг авч авто машинуудад засвар үйлчилгээ хийсэн бөгөөд хувийн хэрэгт бичилт хийгээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Зам, тээвэр хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 5.1.4-т "Зарим үйлдвэрлэгчийн резин дугуйн эдэлгээний гүйлтийн доод хязгаарын нормыг хүснэгт 5.3-т үзүүлэв", 5.2.2-т "Зарим үйлдвэрлэгчийн зай хураагуурын эдэлгээний хугацааны доод хязгаарыг хүснэгт 5.4-т үзүүлэв" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

- Татварын тодорхойлолтоор 1.2 сая төгрөгийн 6 нэр төрлийн татварын өглөг, авлагын тооцоог нийлж баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах:", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- И баримтгүй 83.4 сая төгрөгийн гүйлгээ хийсэн байнгаа нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- Батлагдсан төсвийг 10 хувиас доошгүй хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1.-т "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

#### 4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Зүүнгарын говийн дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа	9.0	233.8	1	114.7	2.0	1.1	6	118.0	0.0	0.0